

ХӨХ ГАН



ХНУКН ГАН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар /

Улаанбаатар хот

**Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх
төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт,
“Хөх ган” Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын
дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Хөх ган” Хувьцаат компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлан болон
санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хавсралт №1-ээр
баталсугай.

Хурлын дарга





ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

“ХӨХ ГАН” ХК-ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

“Хөх ган” ХК-ийн 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр сонгогдон, Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр олгосон бүрэн эрхийн хүрээнд ТУЗ тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирлээ.

Компанийн ТУЗ дараах бүрэлдэхүүнтэйгээр үйл ажилаагаа явууллаа.

ТУЗ-ын дарга: Б.Мөнхтөр

ТУЗ-ын гишүүд: Ц.Батбаяр, Ц.Батболд, Б.Лхагвадорж, Д.Дагвадорж,

Д.Даянбилгүүн, Х.Батхишиг, Д.Чинбат, Д.Энхбат

Үйл ажиллагааны тухай

Тус компани нь дэлхийн зах зээлд төмрийн үнэ эрс унаснаас шалтгаалан төмрийн хүдрийн экспорт буурсан, улс орны эдийн засгийн хүндрэл, валютын ханшны өсөлт болон тус үйлдвэрийн үндсэн түүхий эдийг бэлтгэгч Архангай аймаг дах төмрийн хүдрийн уурхай, баяжмалын үйлдвэр удаан хугацаагаар зогссон зэрэг шалтгааны улмаас 2015 оны 2 –р улирлаас 2017 он бүтэн сул зогсолт хийгээд байна.

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт

“Хөх Ган” ХК Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Аудитын хороо нь Компанийн тухай хуулийн 81.4 дүгээр зүйлийн дагуу үйл ажилаагаа явуулсан бөгөөд “ХӨХ ГАН” ХК –ний санхүүгийн тайланд 2017 оны 12 дугаар сарын 31 байдлаар аудит хийж дүгнэлт гаргалаа.

“ХӨХ ГАН” ХК нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон сангийн сайдын 2004 оны 248 дугаар тушаалаар батлагдсан Аж ахуй нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын дагуу бэлтгэгдсэн байна.

“ХӨХ ГАН” ХК нь Ай Жэй Эй Эйч –Аудитын газраар 4- жил санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгэжээ.

2017 оны байдлаар их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй гэрээ, хэлцэл хийгдээгүй гэж үзэв.

“Хөх Ган” ХК-ийн санхүүгийн тайлан, бүртгэл, үндсэн хөрөнгийн дансанд тусгагдсан авто машин хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссан, дахин ашиглах боломжгүйгээр эвдэрч гэмтсэн, элэгдсэн, засан сайжруулахад илүү их зардал шаардагдах ба цаашид ашиглах боломжгүй болсон тухай тооллогын хэсгийн дүгнэлтээр авто машиний борлуулалт хийгдсэн байна .

Ерөнхий нягтлан бодогчийн санал, фото зураг болон санхүүгийн бусад баримт бичгийг судлан үзээд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1, 19.1.4 дэх зүйл, хэсэг, заалтыг баримталсан болно.

Мөнгө ба хөрөнгө оруулалтын дансны дотор зээл нөхөх албан ёсны ба албан ёсны бус сан байхгүй байна .

Иймд цаашид нөөц сан бүрдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Аудитын хорооны дарга

/С.Алтанцэцэг/

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга:



Б.Мөнхтөр

ХӨХ

ГАН



ХНУКН

ГАН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

“Хөх ган” ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай

“Хөх ган” Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Хөх ган” хувьцаат компанийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсугай.

Хурлын дарга



ХӨХ

ГАН



КНУКН

ГАН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 3

Улаанбаатар хот

Компанийн ТУЗ гишүүд, нарийн бичгийн даргын цалин, ХЭХ-ын зардлыг төсвийг
батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 заалт,
“Хөх ган” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын
тогтоолын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Хөх ган” хувьцаат компанийн 2018 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын болон
төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг 23,657,000 төгрөгөөр баталсугай.

Хурлын дарга



ХӨХ

ГАН



ХНУКН

ГАН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20 16 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 4

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дах заалтыг удирдлага болгон “Хөх ган” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын тогтоолын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Хөх ган” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр
 1. Б.Мөнхтөр
 2. Ц.Батбаяр
 3. Ц.Батболд
 4. Б.Лхагвадорж
 5. Д.Даянбилгүүн
 6. Д.Дагвадорж
2. “Хөх ган” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр
 7. Д.Энхбат
 8. Д.Чинбат
 9. Х.Батхишиг нарыг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр сонгогдсоныг баталсугай.

Хурлын дарга



ХӨХ

ГАН



ХНУКН

ГАН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20 18 оны 09 сарын 30 өдөр

Дугаар 5

Улаанбаатар хот

“Хөх ган” ХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах

“Хөх ган” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын тогтоолын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөх ган” ХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг баталсугай.

Хурлын дарга

